



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Боржигонмандал эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: [Oyun-erdenet@audit.gov.mn](mailto:Oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитор Л.Баянмөнх

Утас: 99997540

Цахим хаяг: [bayanmunkhamina@gmail.com](mailto:bayanmunkhamina@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

№ ДС.ОР.ЛС

№

46

танай

-ны №

-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Дундговь аймгийн Боржигон мандал Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Боржигон мандал Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Боржигон мандал Өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан хаагч нарын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч эрүүл мэндийн даатгалын багц үйлчилгээний урамшуулал 27.9 сая төгрөг, балансын урамшуулал 1.3 сая төгрөгийг давхардуулан олгосон, аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, 15.2.6, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д заасныг зөрчсөн байна.

Эдгээр залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 6.0 дахин их, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд үндсэн хөрөнгө 315.0 сая төгрөгөөр нэмэгдсэний

4825020154

дийлэнх хувийг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө эзэлж байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### **Аудитын гол асуудал**

Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар Дотоод хяналтын багийг байгуулсан боловч байгууллагын аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, төсөв санхүү нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ 83.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,850,212.11</b>	<b>176,560,836.27</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	840,734.62	1,229,361.69
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	840,734.62	1,229,361.69
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	840,734.62	1,229,361.69
31211	Төрийн сангийн харилцах	831,784.54	1,229,361.69
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	8,950.08	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,271,775.00	95,392,258.36
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,271,775.00	95,392,258.36
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	91,737,702.49	79,939,216.22
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	56,445,042.14	29,384,196.62
35110	Тусгай зориулалттай материал	19,216,636.22	11,673,641.62
35130	Эм боох материал	37,228,405.92	17,710,555.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	35,292,660.35	50,555,019.60
35410	Бичиг хэргийн материал	2,547,100.00	2,900,500.00
35420	Аж ахуйн материал	28,072,852.04	41,367,298.80
35430	Сэлбэг хэрэгсэл	715,800.00	1,620,800.00
35440	Түлш, шатах тослох материал	54,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	3,902,908.31	4,666,420.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>154,246,873.92</b>	<b>475,026,354.85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	154,246,873.92	475,026,354.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	139,474,873.92	460,254,354.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	110,553,487.44	400,296,346.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,804,290.20	-29,625,928.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,250,000.00	-9,750,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	85,008,627.15	116,061,637.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,073,380.36	-38,616,954.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,825,787.40	12,021,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,785,357.51	-5,131,745.81
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,772,000.00	14,772,000.00
39301	Програм хангамж	300,800.00	300,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,800.00	-300,800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,772,000.00	14,772,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>256,097,086.03</b>	<b>651,587,191.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ОР ТӨЛБӨР</b>	<b>17,442,392.03</b>	<b>6,831,374.19</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ОР ТӨЛБӨР</b>	17,442,392.03	6,831,374.19
<b>413</b>	<b>Өглөг</b>	17,442,392.03	6,831,374.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,287,982.03	3,517,424.19
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,154,410.00	3,313,950.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>238,654,694.00</b>	<b>644,755,816.93</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	238,654,694.00	644,755,816.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,554,713.52	94,554,713.52
51101	Өмч: - төрийн	94,554,713.52	94,554,713.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	140,387,425.14	546,488,548.07
51210	Өмнөх үеийн үр дүн	114,879,419.46	140,387,425.14
51220	Тайлант үеийн үр дүн	25,508,005.68	406,101,122.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,712,555.34	3,712,555.34
<b>6</b>	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>256,097,086.03</b>	<b>651,587,191.12</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>341,938,905.56</b>	<b>881,644,053.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,357,055.65</b>	<b>369,865,783.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>34,357,055.65</b>	<b>369,865,783.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,467,237.07	341,774,859.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	23,889,818.58	28,090,924.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>307,581,849.91</b>	<b>511,778,270.17</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,271,775.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	9,271,775.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,963,320.90	18,307,450.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,963,320.90	18,307,450.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	280,346,754.01	493,470,820.17
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	280,346,754.01	493,470,820.17
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>316,430,899.88</b>	<b>475,542,930.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>316,430,899.88</b>	<b>475,542,930.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	314,730,899.88	472,792,930.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,728,390.00	274,576,434.69
210101	Үндсэн цалин	128,343,844.67	169,059,836.69
210102	Нэмэгдэл	34,460,153.33	42,110,076.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,697,000.00	8,580,000.00
210104	Урамшуулал	13,227,392.00	54,826,522.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,907,543.90	35,074,767.56
210201	Тэтгэврийн даатгал	22,907,543.90	35,074,767.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,098,634.95	9,724,519.91
210301	Гэрэл, цахилгаан	1,494,194.95	2,017,309.91
210302	Түлш, халаалт	9,450,000.00	7,390,410.00
210303	Цэвэр, бохир ус	154,440.00	316,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>46,157,337.15</b>	<b>23,557,865.24</b>
210401	Бичиг хэрэг	6,812,020.00	3,056,714.00
210402	Тээвэр, шатахуун	7,734,657.00	2,515,976.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	806,400.00	1,579,537.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,003,900.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,800,360.15	16,405,637.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,952,052.16	76,568,367.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,952,052.16	76,568,367.26
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,542,600.00	844,937.51
210604	Урсгал засвар	9,542,600.00	844,937.51
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	716,000.00	2,606,000.00
210702	Дотоод албан томилот	716,000.00	2,606,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,623,509.80</b>	<b>6,756,472.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,029,277.00	6,126,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	478,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,132.80	4,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	0.00	98,972.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	79,100.00	87,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,004,831.92	43,083,566.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,370,000.00	20,218,188.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,634,831.92	22,865,378.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,700,000.00	2,750,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,700,000.00	2,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	2,750,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>25,508,005.68</b>	<b>406,101,122.93</b>

5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>25,508,005.68</b>	<b>406,101,122.93</b>
---	--------------------------------	----------------------	-----------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>298,310,074.91</b>	<b>425,657,786.81</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>298,310,074.91</b>	<b>425,657,786.81</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,963,320.90	18,307,450.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,963,320.90	18,307,450.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	280,346,754.01	407,350,336.81
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	280,346,754.01	407,350,336.81
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>281,705,197.81</b>	<b>423,399,159.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>281,705,197.81</b>	<b>423,399,159.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>280,005,197.81</b>	<b>420,649,159.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	170,989,269.11	288,154,753.30
210101	Үндсэн цалин	115,678,268.78	189,852,891.61
210102	Нэмэгдэл	36,496,608.33	44,449,326.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,697,000.00	8,535,000.00
210104	Урамшуулал	13,117,392.00	45,317,535.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,828,073.95	32,267,006.79
210201	Тэтгэврийн даатгал	22,828,073.95	32,267,006.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,123,842.95	10,124,519.91
210301	Гэрэл, цахилгаан	1,494,194.95	2,017,309.91
210302	Түлш, халаалт	12,750,000.00	7,790,410.00
210303	Цэвэр, бохир ус	879,648.00	316,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,025,082.00	33,883,227.74
210401	Бичиг хэрэг	6,373,320.00	3,410,114.00
210402	Тээвэр, шатахуун	3,443,457.00	3,066,576.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	806,400.00	1,579,537.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,003,900.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,398,005.00	25,827,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	21,996,300.00	42,967,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,911,300.00	37,567,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,085,000.00	5,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,384,320.00	3,555,000.00
210602	Тавилга	-280,000.00	0.00
210604	Урсгал засвар	15,664,320.00	3,555,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	716,000.00	2,606,000.00
210702	Дотоод албан томилолт	716,000.00	2,606,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,493,509.80	6,764,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,899,277.00	6,126,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	478,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,132.80	4,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	0.00	98,972.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	79,100.00	95,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,448,800.00	327,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,448,800.00	327,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,700,000.00</b>	<b>2,750,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,700,000.00	2,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	2,750,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>16,604,877.10</b>	<b>2,258,627.07</b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,787,500.00</b>	<b>1,870,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,787,500.00</b>	<b>1,870,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	15,787,500.00	1,870,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,787,500.00	1,870,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(15,787,500.00)</b>	<b>(1,870,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	817,377.10	388,627.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,357.52	840,734.62
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	840,734.62	1,229,361.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	94,554,713.52	3,712,555.34	114,879,419.46	213,146,688.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>94,554,713.52</b>	<b>3,712,555.34</b>	<b>114,879,419.46</b>	<b>213,146,688.32</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	25,508,005.68	25,508,005.68
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>94,554,713.52</b>	<b>3,712,555.34</b>	<b>140,387,425.14</b>	<b>238,654,694.00</b>
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>94,554,713.52</b>	<b>3,712,555.34</b>	<b>140,387,425.14</b>	<b>238,654,694.00</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>94,554,713.52</b>	<b>3,712,555.34</b>	<b>140,387,425.14</b>	<b>238,654,694.00</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	406,101,122.93	406,101,122.93
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>94,554,713.52</b>	<b>3,712,555.34</b>	<b>546,488,548.07</b>	<b>644,755,816.93</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>426,489,571.35</b>	<b>425,260,209.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>426,489,571.35</b>	<b>425,260,209.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>423,739,571.35</b>	<b>422,510,209.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	289,384,114.30	288,154,753.30
210101	Үндсэн цалин	191,082,253.30	189,852,891.61
210102	Нэмэгдэл	44,449,326.69	44,449,326.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,535,000.00	8,535,000.00
210104	Урамшуулал	45,317,535.00	45,317,535.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,267,006.79	32,267,006.79
210201	Тэтгэврийн даатгал	32,267,006.79	32,267,006.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,124,519.91	10,124,519.91
210301	Гэрэл, цахилгаан	2,017,309.91	2,017,309.91
210302	Тулш, халаалт	7,790,410.00	7,790,410.00
210303	Цэвэр, бохир ус	316,800.00	316,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,874,277.66	33,874,277.66
210401	Бичиг хэрэг	3,410,144.00	3,410,144.00
210402	Тээвэр, шатахуун	3,066,576.50	3,066,576.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,570,587.16	1,570,587.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,827,000.00	25,827,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	42,967,580.00	42,967,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,567,580.00	37,567,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,400,000.00	5,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,425,000.00	5,425,000.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	480,000.00	480,000.00
210602	Тавилга	1,390,000.00	1,390,000.00
210604	Урсгал засвар	3,555,000.00	3,555,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,606,000.00</b>	<b>2,606,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,606,000.00	2,606,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,764,072.00</b>	<b>6,764,072.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,126,100.00	6,126,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,000.00	4,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	98,972.00	98,972.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	95,000.00	95,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>327,000.00</b>	<b>327,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	327,000.00	327,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,750,000.00</b>	<b>2,750,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,750,000.00</b>	<b>2,750,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,750,000.00	2,750,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>426,489,571.35</b>	<b>425,657,786.81</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>18,307,450.00</b>	<b>18,307,450.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	18,307,450.00	18,307,450.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>407,350,336.81</b>	<b>407,350,336.81</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	407,350,336.81	407,350,336.81
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>831,784.54</b>	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	831,784.54	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>831,784.54</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>1,229,361.69</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,867.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 28,911.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 19,955.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

#### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 48,867.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 28,061.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 19,955.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

#### 3.1 Албан шаардлага

1. Байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нарын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1,267.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Эмч, сувилагч нарын ажлыг ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч эрүүл мэндийн даатгалын багц үйлчилгээний урамшууллыг давхардуулан тооцож **27,644.6** мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохиостой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Бараа материалын данстай холбоотой

##### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд аж ахуйн материалын дансанд 1,755.0 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д: /"Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"/ гэж заасныг, мөн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна

##### Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв бүртгэж, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэж, хариуг нотлох баримтын хамт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

#### 3.2.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 5 нэр төрлийн 18,200.4 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д: "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-д заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

##### Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, хариуг нотлох баримтын хамт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нарын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон	1	1,267.2			1	1,267.2				
Эмч, сувилагч нарын ажлыг ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч эрүүл мэндийн даатгалын багц үйлчилгээний урамшууллыг давхардуулан тооцож олгосон.	1	27,644.6			1	27,644.6				
Тайлант хугацаанд аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан.	1	1,755.0					1	1,755.0		
Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.	1	18,200.4					1	18,200.4		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>48,867.3</b>			<b>2</b>	<b>28,911.8</b>	<b>2</b>	<b>19,955.4</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
			Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		